



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23

№

377

танай

-ны №

-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Б.ЭНХТӨР ТАНАА

Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт . 24 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030980

D:\Desktop\2024\Word\Базар 5нар\2024.02.23.580.NDH.A5.docx

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/376/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn
Аудитын менежер: Д.Нар-Од
Утас: 99091993 Цахим хаяг: narod.d@solidunity.mn
Аудитор: Г.Нандинцэцэг
Утас: 99019509 Цахим хаяг: nandintsetseg.g@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
4. Аудитын тайлан.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 378

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Б.ЭНХТӨР
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын тухай хууль 2023 оны 7-р сарын 07-ны өдөр шинэчлэгдэж, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болж 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчлагдсан. Энэхүү шинэчилсэн хуульд нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын газар болж нийгмийн даатгалын тогтолцоонд өөрчлөлт орсон байна. Үүнтэй холбоотой бүтэц, орон тоо, цалингийн шатлал, санхүүжилтийн хэлбэрт өөрчлөлт орохоор байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 96.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,392,012,066.31	118,540,887,488.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,015,072,622.86	20,719,028,201.89
312	Банканд байгаа бэлэн мөнгө	16,015,072,622.86	20,719,028,201.89
3121	Төгрөг	16,015,072,622.86	20,719,028,201.89
31211	Төрийн сангийн харилцах	98,954,378.66	252,735,157.02
31213	Арилжааны банк дахь харилцах	15,916,118,244.20	20,466,293,044.87
33	АВЛАГА	136,360,464,407.45	97,782,743,257.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	64,575,387,250.13	67,509,082,223.43
33300	Татаас санхүүжилтийн авлага	71,426,179,941.34	29,351,831,673.70
335	Бусад авлага	358,897,215.98	921,829,360.17
3351	Байгууллагаас авах авлага	358,897,215.98	921,829,360.17
35	БАРАА МАТЕРИАЛ	16,475,036.00	39,116,029.00
354	Хангамжийн материал	16,475,036.00	39,116,029.00
35410	Бичиг хэргийн материал	660,330.00	4,441,640.00
35420	Аж ахуйн материал	10,574,490.00	21,341,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,250,000.00	11,026,090.00
35470	Бусад хангамжийн материал	1,990,216.00	2,306,999.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,811,954,382.41	1,749,696,279.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,811,954,382.41	1,749,696,279.85
392	Биет хөрөнгө	1,790,356,922.41	1,728,098,819.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,834,508,186.00	1,834,508,186.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(189,685,485.60)	(221,033,191.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,210,000.00	12,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,442,000.00)	(4,884,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	131,491,799.00	130,031,349.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,362,980.60)	(48,261,952.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,533,165.00	122,499,705.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(85,895,761.39)	(96,971,276.45)
393	Биет бус хөрөнгө	21,597,460.00	21,597,460.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,597,460.00	21,597,460.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	154,203,966,448.72	120,290,583,768.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,664,565,483.03	5,378,252,174.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,664,565,483.03	5,378,252,174.18
413	Өглөг	140,800,790.45	497,893,401.88
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	140,800,790.45	497,893,401.88
414	Урьдчилж орсон орлого	2,523,764,692.58	4,880,358,772.30
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	2,523,764,692.58	4,880,358,772.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	151,539,400,965.69	114,912,331,593.86
51	Засгийн газрын хувь оролцоо	611,489,291.11	611,489,291.11
51100	Засгийн газрын оруулсан капитал	611,489,291.11	611,489,291.11
512	Хуримтлагдсан үр дүн	150,927,911,674.58	114,300,842,302.75
51210	Өмнөх үеийн үр дүн	207,284,560,704.70	150,389,033,965.86

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
51220	Тайлант үеийн үр дүн	(56,356,649,030.12)	(36,088,191,663.11)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	154,203,966,448.72	120,290,583,768.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	525,264,098,705.90	658,826,781,152.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	494,034,982,087.78	621,056,970,274.60
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	494,034,982,087.78	621,056,970,274.60
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	344,460,041,423.29	433,057,001,797.65
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	36,851,706,428.94	46,222,924,660.83
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	27,600,556,018.66	36,955,264,975.68
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	7,311,406,571.88	10,168,510,676.60
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	77,811,271,645.01	94,653,268,163.84
12	Татварын бус орлого	404,032,936.94	719,894,789.72
120	Нийтлэг татварын бус орлого	404,032,936.94	719,894,789.72
120002	Хүүгийн орлого	2,222,646.28	293,774,312.04
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	88,527,859.66	121,091,206.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,305,025.66	116,456,775.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,082,834.00	4,634,430.27
120009	Бусад орлого	313,282,431.00	305,029,271.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,825,083,681.18	37,049,916,088.28
1310	Улсын төсвөөс	28,352,126,131.00	35,204,403,648.28
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,352,126,131.00	35,204,403,648.28
1330	Төсвийн захирагчдаас	1,317,365,150.18	5,807,740.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,317,365,150.18	5,807,740.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,155,592,400.00	1,839,704,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,128,555,800.00	1,839,704,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,036,600.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	581,620,747,736.02	694,914,972,815.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,620,747,736.02	694,914,972,815.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,185,641,880.07	1,743,759,011.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,479,844.43	1,345,913,497.82
210101	Үндсэн цалин	727,386,484.60	784,524,822.89
210102	Нэмэгдэл	99,875,406.91	273,527,604.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,921,176.51	140,135,672.91
210104	Урамшуулал	32,296,776.41	147,725,397.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,047,319.44	206,513,876.42

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
210201	Тэтгэврийн даатгал	66,772,088.89	142,353,116.67
210202	Тэтгэмжийн даатгал	10,746,646.11	16,598,026.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,277,132.63	13,165,521.42
210204	Ажилгүйдлийн даатгал	2,113,786.53	3,118,090.89
210205	Эрүүл мэндийн даатгал	21,137,665.28	31,279,120.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,247,213.38	39,792,693.44
210301	Гэрэл, цахилгаан	11,006,200.00	19,354,600.00
210302	Түлш, халаалт	7,481,096.07	12,761,876.70
210303	Цэвэр, бохир ус	5,759,917.31	7,676,216.74
2104	Хангамж, бараа материалын зардал	24,203,821.28	31,912,059.62
210401	Бичиг хэрэг	12,258,420.00	15,669,580.00
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00	1,185,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,131,241.28	5,548,312.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	1,180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,894,160.00	7,815,690.00
210408	Бараа материал акталсны зардал	-	512,777.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,279,000.00	12,237,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	8,779,000.00	12,237,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,128,004.90	37,964,591.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,840,000.00	3,420,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,700,000.00	5,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	569,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	94,047.00	94,047.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,554,090.00	27,123,480.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,879,883.90	997,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,256,676.64	69,424,542.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,850,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,256,676.64	66,574,542.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580,435,105,855.95	693,171,213,804.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	182,619,559,969.00	221,261,524,356.28
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	182,608,778,437.00	221,138,542,233.28
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,781,532.00	11,818,368.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	111,163,755.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	397,815,545,886.95	471,909,689,448.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	397,815,545,886.95	471,909,689,448.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(56,356,649,030.12)	(36,088,191,663.11)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(56,356,649,030.12)	(36,088,191,663.11)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	582,555,446,735.38	700,782,081,426.05
11	ТАТВАРЫН ОРЛОГО	493,292,269,877.57	618,537,887,705.09
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	493,292,269,877.57	618,537,887,705.09
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	343,963,158,717.25	431,390,262,059.95
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	36,806,143,157.66	45,971,772,536.60
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	27,550,284,035.20	36,803,328,923.53
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	7,278,298,198.04	10,098,852,622.01
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	77,694,385,769.42	94,273,671,563.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	421,155,257.81	907,209,220.96
120	Нийтлэг татварын бус орлого	421,155,257.81	907,209,220.96
120002	Хүүгийн орлого	2,222,646.28	257,068,551.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	418,932,611.53	650,140,669.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	418,792,611.53	650,140,669.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,842,021,600.00	81,336,984,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	86,456,429,200.00	79,497,279,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	86,456,429,200.00	79,497,279,800.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,230,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,155,592,400.00	1,839,704,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,128,555,800.00	1,839,704,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,036,600.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	582,320,403,099.20	696,078,125,847.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,320,403,099.20	696,078,125,847.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,120,464,888.13	1,693,699,731.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	922,918,851.01	1,345,913,497.82
210101	Үндсэн цалин	732,825,491.18	766,463,956.52
210102	Нэмэгдэл	99,875,406.91	272,181,767.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,921,176.51	165,774,133.58
210104	Урамшуулал	32,296,776.41	141,493,639.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,160,661.46	206,513,876.42
210201	Тэтгэврийн даатгал	74,329,161.46	140,917,787.02
210202	Тэтгэмжийн даатгал	11,457,900.00	16,598,026.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,166,200.00	13,238,421.84

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
210204	Ажилгүйдлийн даатгал	2,291,600.00	3,243,775.93
210205	Эрүүл мэндийн даатгал	22,915,800.00	32,515,864.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,247,213.38	39,792,693.44
210301	Гэрэл, цахилгаан	11,006,200.00	19,354,600.00
210302	Түлш, халаалт	7,481,096.07	12,761,876.70
210303	Цэвэр, бохир ус	5,759,917.31	7,676,216.74
2104	Хангамж, бараа материалын зардал	25,611,041.28	41,417,002.62
210401	Бичиг хэрэг	12,378,150.00	14,970,490.00
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00	1,185,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,131,241.28	5,548,312.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	1,180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,181,650.00	18,532,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,279,000.00	19,745,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	7,508,100.00
210604	Урсгал засвар	8,779,000.00	12,237,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,248,121.00	37,466,811.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,840,000.00	3,920,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,700,000.00	5,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	569,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	94,047.00	94,047.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,554,090.00	27,123,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	581,199,938,211.07	694,384,426,115.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	183,384,392,324.12	222,474,736,667.42
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	183,000,025,321.36	221,301,627,965.57
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,781,532.00	11,818,368.00
213205	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	373,585,470.76	1,050,126,578.85
213209	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	111,163,755.00
2133	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	397,815,545,886.95	471,909,689,448.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	397,815,545,886.95	471,909,689,448.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	235,043,636.18	4,703,955,579.03
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	235,043,636.18	4,703,955,579.03
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,780,028,986.68	16,015,072,622.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,015,072,622.86	20,719,028,201.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,489,291.11	207,540,796,910.47	208,152,286,201.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(256,236,205.77)	(256,236,205.77)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	611,489,291.11	207,284,560,704.70	207,896,049,995.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(56,356,649,030.12)	(56,356,649,030.12)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,489,291.11	150,927,911,674.58	151,539,400,965.69
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	611,489,291.11	150,927,911,674.58	151,539,400,965.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(538,877,708.72)	(538,877,708.72)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	611,489,291.11	150,389,033,965.86	151,000,523,256.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	(36,088,191,663.11)	(36,088,191,663.11)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,489,291.11	114,300,842,302.75	114,912,331,593.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	НИЙТ ДҮН				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	232,486,214,900.00	223,118,309,819.87	9,367,905,080.13	96.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,486,214,900.00	223,118,309,819.87	9,367,905,080.13	96.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,726,494,900.00	1,693,699,731.30	32,795,168.70	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,369,607,700.00	1,345,913,497.82	23,694,202.18	98.3
210101	Үндсэн цалин	784,735,300.00	766,463,956.52	18,271,343.48	97.7
210102	Нэмэгдэл	266,113,400.00	272,181,767.80	(6,068,367.80)	102.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,596,000.00	165,774,133.58	2,821,866.42	98.3
210104	Урамшуулал	150,163,000.00	141,493,639.92	8,669,360.08	94.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,538,900.00	206,513,876.42	1,025,023.58	99.5
210201	Тэтгэврийн даатгал	141,320,500.00	140,917,787.02	402,712.98	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,677,100.00	16,598,026.93	79,073.07	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,553,700.00	13,238,421.84	315,278.16	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,263,400.00	3,243,775.93	19,624.07	99.4
210205	Эрүүл мэндийн даатгал	32,724,200.00	32,515,864.70	208,335.30	99.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,112,600.00	39,792,693.44	319,906.56	99.2
210301	Гэрэл, цахилгаан	19,354,600.00	19,354,600.00	-	100.0
210302	Түлш, халаалт	13,052,000.00	12,761,876.70	290,123.30	97.8
210303	Цэвэр, бохир ус	7,706,000.00	7,676,216.74	29,783.26	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	43,577,000.00	41,417,002.62	2,159,997.38	95.0
210401	Бичиг хэрэг	15,851,400.00	14,970,490.00	880,910.00	94.4
210402	Тээвэр, шатахуун	1,588,500.00	1,185,700.00	402,800.00	74.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,077,100.00	5,548,312.62	528,787.38	91.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	1,180,000.00	55,000.00	95.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,825,000.00	18,532,500.00	292,500.00	98.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,034,000.00	19,745,850.00	288,150.00	98.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,534,000.00	7,508,100.00	25,900.00	99.7
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,237,750.00	262,250.00	97.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,774,700.00	37,466,811.00	5,307,889.00	87.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,650,000.00	3,920,200.00	729,800.00	84.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,700,000.00	5,700,000.00	-	100.0

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	569,100.00	230,900.00	71.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	59,984.00	40,016.00	60.0
210807	Газрын төлбөр	100,000.00	94,047.00	5,953.00	94.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	31,424,700.00	27,123,480.00	4,301,220.00	86.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,850,000.00	2,850,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,850,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	230,759,720,000.00	221,424,610,088.57	9,335,109,911.43	96.0
213203	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	230,634,668,600.00	221,301,627,965.57	9,333,040,634.43	96.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,962,000.00	11,818,368.00	143,632.00	98.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	113,089,400.00	111,163,755.00	1,925,645.00	98.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	232,486,214,900.00	604,368,345,001.62	371,882,130,101.62	260.0
1310	Улсын төсвөөс санхүүжих	79,497,279,800.00	79,497,279,800.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	79,497,279,800.00	79,497,279,800.00	0.00	100.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	152,988,935,100.00	524,511,439,574.52	371,522,504,474.52	342.8
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	152,988,935,100.00	524,511,439,574.52	371,522,504,474.52	342.8
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0	359,625,627.10	359,625,627.10	-
120004.1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	359,625,627.10	359,625,627.10	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	16,015,072,622.86	16,015,072,622.86	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	20,719,028,201.89	20,719,028,201.89	-
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСАД БҮГД	61	61	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	54	54	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд “Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэнэ” гэсэн чанарын бодлого баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж төлбөр олгох үйл ажиллагаа эрхэлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- МУ-ын ЗГ-ын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 тоот "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоол;
- МУ-ын ЗГ-ын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 тоот "Төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" ;
- Засгийн газрын 2023 оны 213 дугаар тогтоол “Цалингийн хэмжээ итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай журам”
- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 239 дүгээр тогтоол "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай журам”
- Засгийн газрын 2023 оны 60 дугаар тогтоол “Даатгуулагчийн төрөл, код шинээр батлах тухай журам”
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 10 дугаар тогтоол “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоох тухай”

- НДЕГ-ын даргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/78 дугаар тушаал "Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар"
- НДЕГ-ын даргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/78 дугаар тушаал "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын болон туслах үйл ажиллагааны орлогын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын тасгийн дарга дотоод аудитор, магадлагч эмч, хяналтын 9 байцаагч нийт 11 орон тоотой. Дотоод аудит нь нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, тэтгэвэр, тэтгэмж тогтоолттой холбоотой зөрчил дутагдлыг илрүүлэх, үйл явцыг үнэлж, дүгнэх үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн амаржсаны тэтгэмжийн болон эмнэлгийн хуудасны бичилт, тэтгэмжийн бодолт, олголтын тооцоо зөв хийгдсэн эсэхийг үнэлж шалгадаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/64, А/65 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,913,382.7 мянган төгрөгөөр буюу 22.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,015,072.6	20,719,028.2	4,703,955.6
Авлага	136,360,464.4	97,782,743.3	(38,577,721.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	16,475.0	39,116.0	22,641.0
Үндсэн хөрөнгө	1,811,954.4	1,749,696.3	(62,258.1)
Нийт хөрөнгө	154,203,966.4	120,290,583.8	(33,913,382.7)
Өр төлбөр	2,664,565.5	5,378,252.2	2,713,686.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	151,539,401.0	114,912,331.6	(36,627,069.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	154,203,966.4	120,290,583.8	(33,913,382.7)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данснууд байна.

Авлагын дансны үлдэгдэл 97,782,743.3 мянган төгрөг болж 38,577,721.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд улсын төсвийн санхүүжилтийн авлага мөнгөөр төлөгдөж орж ирсэн шалтгаалжээ. Авлагын үлдэгдэл нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, улсын төсвийн санхүүжилтийн авлагаас бүрдэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2022 оны жилийн эцэст 64,574,494.8 мянган төгрөг байснаас 2023 оны жилийн эцэст 67,509,082.2 мянган төгрөг болж 4.5 хувиар өссөн ба үүнээс урсгал авлага 21,904,610.9 мянган төгрөг, 120 хоногоос дээш насжилттай үүсэн авлага 45,604,471.3 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,116.0 мянган төгрөг болж, 22,641.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэд үйл ажиллагаанд ашиглагдах хангамжийн шинжтэй аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн материалын өсөлт нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,749,696.3 мянган төгрөг болж, 62,258.1 мянган төгрөгөөр буурсан гол шалтгаан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 5,378,252.2 мянган төгрөг болж, 2,713,686.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэд урьдчилж орсон тэтгэврийн сангийн санхүүжилтийн орлого нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 36,627,069.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 414,954,468.8 мянган төгрөг, нийт зарлагыг 227,649,270.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 11,919,373.9 мянган төгрөгөөр бууруулж, 215,729,896.5 мянган төгрөгөөр баталсан байна. Байгууллага нь 2023 оны төсвийн төсөлд тэтгэврийг 10 хувийн өсөлтөөр нэмэгдүүлэхээр тооцон хүргүүлсэн боловч 2023 оны төсвийн төсөл батлагдах үед уг тэтгэврийг нэмэгдүүлэх шийдвэр гараагүй байсан тул тэтгэврийн даатгалын сангийн зардлыг бууруулан баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 16,756,318.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 79,497,279.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 152,988,935.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 79,497,279.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 618,537,887.7 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд төлөвлөсөн 1,839,704.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 223,118,309.8 мянган төгрөгийг зарцуулж, 471,909,689.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын гүйцэтгэл 221,309,167.8 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь 11,177,046.6 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны нийт зардлын гүйцэтгэл 1,809,142.0 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 22,990.2 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 229.9 мянган төгрөг, мэдээлэл, сурталчилгааны зардлаас 600.0 мянган төгрөг, зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлсний зардлаас 4,593.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлаас 1,925.6 мянган төгрөг гэх мэт нийт 30,562.7 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,652,647.7	1,629,657.5	22,990.2	98.6
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	14,850.0	14,620.1	229.9	98.5
3	80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	3,300.0	2,700.0	600.0	81.8
4	80813-Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	800.0	720.2	79.8	90.0
5	80224-Зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлс	43,055.6	38,462.0	4,593.6	89.3
6	80802-Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	113,089.4	111,163.8	1,925.6	98.3
7	80813-Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	2,800.0	2,770.0	30.0	98.9
8	80820-Бусад тусламж дэмжлэг	9,162.0	9,048.4	113.6	98.8
	Нийт	1,839,704.7	1,809,142.0	30,562.7	98.3

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд зааснаар улсын төсвийн санхүүжилтээс 79,497,279.8 мянган төгрөг нийгмийн даатгалын сангаас 515,484,713.4 мянган төгрөг, нийт 594,981,993.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 604,368,345.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, шимтгэлийн орлогыг 101.6 хувиар биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэрт	505,438,723.9	511,115,992.2	5,677,268.3	101.1
Тэтгэмж	45,454,037.1	46,073,998.9	619,961.9	101.4
ҮОМШӨ	33,935,378.5	37,031,160.1	3,095,781.6	109.1
Ажилгүйдэл	10,153,853.8	10,147,193.8	(6,660.1)	99.9
Нийт дүн	594,981,993.2	604,368,345.0	9,386,351.8	101.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 онд тусгайлсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг нийслэлийн нийгмийн даатгалын газар зохион байгуулан явуулдаг.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг зөв тооцож олгох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитор Г.Нандинцэцэг, Ү.Цэцэгмаа, аудиторын туслах Э.Цэнддорж, Э.Мэндсайхан, Э.Хонгорзул нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 211 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ:

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 581,620,747.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,816,207.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгахад дэд дарга, орлогч дарга, зөвлөхийн албан тушаалын орон тоогүй, дуудлагын автомашин ашиглаагүй, худалдан авах ажиллагаа нь нийслэлийн нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулагдаж нь хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.

Барилга байгууламжийн дулаан, халаалтыг хэмнэлтийн горимд тохируулан тоолуур ашиглан, талбайн хэмжээгээр төлбөрийн тооцоог хийж дулааны зардлыг хэмнэсэн байна. "Elantra" маркийн суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвгэрээр сольсон байгаа нь Стандарт, хэмжилзүйн газрын даргын баталсан "MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг: Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалт "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" заалтыг хэрэгжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 онд нийт 1,293,422,772.7 мянган төгрөгийн 17,947 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомж болон төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн зарцуулалт нь нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 29,794.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 5 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 29,794.8 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3,765,530.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, 3 албан шаардлага өгснөөс 7 зөрчлийг биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	882,443.9	2	882,443.9	98.3
Зөвлөмж	4	2,883,087.0	4	2,883,087.0	100
Нийт дүн	7	3,765,530.9	6	3,765,530.9	99.1

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайланд засгийн газрын хувь оролцоо данс 611,489.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй, энэхүү засгийн газрын хувь оролцооны дүнгийн өмнөх үеүдийн ажил гүйлгээг шалгахгаар төлөвлөсөн боловч нийгмийн даатгалын үйл ажиллагааны санхүүгийн программ 2022 онд өөрчлөгдөж өмнөх үеийн санхүүгийн программыг аудитын хугацаанд ашиглах боломжгүй байсан. Иймээс дараагийн аудитаар өмнөх үеийн программ болон холбогдох шийдвэрийг хянан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,002.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 18,002.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн тооцоолол, бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооны хүснэгтийг нийгмийн даатгалын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайлантай /ерөнхий дэвтэр/ тулган шалгахад цалингийн зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийгмийн даатгалын тайлан, цалингийн тооцооны хүснэгт дэх дүнгүүд 5,507.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" заалттай нийцэхгүй ба, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцоолол, журнал бичилтэд тавих хяналтыг сайжруулж, нийгмийн даатгалын тайланд тайлагнасан дүнтэй тулган шалгаж байх.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд ажлаас чөлөөлөгдөн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон хоёр ажилтанд ажилласан хугацаанд ногдох амралтын цалин 922.5 мянган төгрөгийг тооцож олгоогүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110.3. "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12-р сарын 06-ны өдрийн А/191 дугаар тушаалын дагуу ажилласан хугацаанд нь ногдох амралтын цалинг тооцож олгох журам"-ын заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалин олгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засвар үйлчилгээний ажил дуусаагүй гэрээ дүгнэсэн акт хийгдээгүй байхад 11,500.0 мянган төгрөгийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээ нь дуусаж гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй тайлант хугацаанд хамаарахгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлагнах.

4. Хувь хүний орлогын албан татварын тайлан, хөнгөлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан буюу маягт ТТ-11-т гэрээт ажилтны 19,674.0 мянган төгрөгийн орлогыг гэрээт буюу 6-р мөрөнд тайлагнаагүй, 1-р мөр буюу үндсэн ажилтнаар тайлагнасан байна. Үүнтэй холбоотойгоор 72.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан татварын хөнгөлөлт бодогдсон байгаа нь хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1. “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн орон тооны бус давхар ажил гүйцэтгэдэг ажилчдыг цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд тайлагнахдаа хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэхгүй байх. Гэрээт ажилчдыг уг тайланд зөв үзүүлэлтээр тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс												
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Засвар үйлчилгээний гэрээ дүгнэсэн акт хийгдээгүй ажил нь дуусаагүй зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн	1	11,500.0						1	11,500.0				
Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд гэрээт ажилтны 19,674,072.00 төгрөгийн орлогыг үндсэн ажилтнаар тайлагнасан байна. Үүнтэй холбоотойгоор 72.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт бодогдсон байна.	1	72.1						1	72.1				
Цалингийн тооцооны хүснэгт, нийгмийн даатгалын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайлан хоорондоо зөрүүтэйгээр тайлагнагдсан.	1	5,507.8						1	5,507.8				
Тайлант хугацаанд ажлаас гарсан 2 ажилтны ажилласан хугацаанд ногдох амралтын цалин тооцож олгоогүй.	1	922.5						1	922.5				
Дүн	4	18,002.4						4	18,002.4				